

**ЙИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНЕГ-ын 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 89%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ИНЕГ-ын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
130	83	16	19	4	8	-	-	88,5%

2.2. МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Хэрэгжих боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
5	1	-	-	-	4	-	-	44%

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%					

14	5	5	4	-	-	-	69,3%
----	---	---	---	---	---	---	-------

2.4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
43	35	4	2	-	-	2	93,7%

2.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл		Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
ИНЕГ	төсөв, гүйцэтгэл	8	6	2	-	-	-	92.5%
	хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	1	1	-	-	-	-	100%
	бусад	5	5	-	-	-	-	100%
ИНҮТ	төсөв, гүйцэтгэл	8	5	3	-	-	-	88,7%
	хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	4	1	-	-	-	94%
	бусад	8	8	-	-	-	-	100%
Нийт		35	29	6	-	-	-	94,8%

2.6. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	46	34	4	2	-	6	93,5%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

ИНЕГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, яамтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Хэрэгжилтийн байдал:

1) ИНЕГ-ын 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 89%-тай байна.

2) Эдгээр үзүүлэлтүүдээс Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт хамгийн бага буюу 44%-аар үнэлэгдсэн байна. Энэ нь Концессын тухай хуулийн хугацаа хүчин төгөлдөр бус болсонтой холбоотойгоор орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийн уралдаант шалгаруулалт тодорхойгүй хугацаагаар хойшлогдсоноос шалтгаалсан байна.

3) 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 130 арга хэмжээний хэрэгжилт 88,5% байна. Үүнээс 78,5% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 21,5% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1: Агаарын тээврийг либералчилна.	14	87.8%
Зорилт 2: Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгоно.	8	88.7%
Зорилт 3: Ая тухтай, хямд тийзтэй, хүртээмжтэй нислэгийг зорчигчдод хүргэнэ.	12	94.2%
Зорилт 4: Дэлхийн агаарын навигацийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан техник технологийн дэвшилд суурилсан агаарын навигацийн үйлчилгээг хөгжүүлнэ.	12	77.5%
Зорилт 5: Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг сайжруулна.	7	97.1%
Зорилт 6: Нисэх буудлуудын үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг сайжруулна.	24	74.6%
Зорилт 7: Иргэний нисэхийн салбарын аюулгүй ажиллагааны зохицуулалтыг хийнэ.	12	100%
Зорилт 8: Иргэний нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгохтой холбоотой харилцааг зохицуулна.	8	100%
Зорилт 9: Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавина.	5	92%
Зорилт 10: Осол зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлнэ.	1	100%
Зорилт 11: Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангана.	2	85%
Зорилт 12: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.	11	90.9%
Зорилт 13: Салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг шинэчлэхэд болон хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангана.	5	90%
Зорилт 14: Үр ашиггүй зардлыг бууруулж, батлагдсан төсвөө 10-иас доошгүй хувь хэмнэнэ.	3	96.7%
Зорилт 15: Бодлого, хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ.	2	100%
Зорилт 16: ИНЕГ, харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангана.	2	100%
Зорилт 17: Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах, өгөгдлийн сангийн бүртгэл хөтлөх, хяналт тавих.	2	85%

5) 2024 онд 2.2 сая зорчигч, 12.0 мянган тн ачаа тээвэрлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 2,167,270 зорчигч, 10,171.2 тонн ачаа, 222.8 тонн шуудан тээвэрлэсэн үзүүлэлттэй байна. 2023 онтой харьцуулахад олон улсын чиглэл 33% буюу 434 мянган зорчигчоор, орон нутгийн чиглэл 0,3% буюу 1,2 мянган зорчигчоор нэмэгдсэн бөгөөд ачаа тээвэрлэлт 28%-аар өсөж, шуудан 65%-аар буурсан байна

6) Энэ онд улсын төсөвт 150.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголоор 80.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр шинэчлэн батлагдсаны дагуу 80.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

7) 2023 он, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт ахицтай байна. Үүнд

- Хоёр талт агаарын хэлэлцээр байгуулах, үзэглэх, нэмэлт өөрчлөлт оруулах, ИНЕГ-ын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ТАЗ-өөр хянуулж, ИНЕГ-ын дарга баталгаажуулах зэрэг хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг яаралтай дуусгах;
- ЗТХ-ийн сайдын 2023.04.23-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023-2025 онд “Монголд зочлох жил”-ын хүрээнд аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг өгсний дагуу орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаа, тохижилтыг сайжруулж, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх тодорхой ажил төлөвлөн дэс дараатай арга хэмжээ авах;
- 2024 онд хэрэгжүүлэх 5 онцлох ажлыг тодорхойлон нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, сар бүр ЗТХЯ-д тайланг ирүүлэх;
- Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтэд тусгасан мэдээллүүдийг веб хуудсандаа тогтоосон хугацаанд тогтмол байрлуулах,

8) Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журам, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөө, Албадлагын дүрэм, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлах зэрэг хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг яаралтай дуусгах, Концессын зүйлийн жагсаалтад тусгуулсан орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, ИНЕГ-ын Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилгыг ашиглалтад оруулах, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг засварын төв, сургалтын төвийн зориулалтаар ашиглах төсөл боловсруулж, хөрөнгө оруулалт татах ажлыг зохион байгуулах, Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барих, “Өлгий” нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх зэрэг ажлууд удаашралтай хэвээр байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. ИНЕГ болон ИНУТ-ийн бүтэц, орон тоо, дүрмийг хууль тогтоомжид нийцүүлэн оновчтой боловсруулж, шинэчлэн батлуулах, агентлагийн албан хаагчдыг төрийн албан хаагч болгох, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зэрэг ажлуудыг 2025 оны I сард багтаан дуусгах,

2. Концессын зүйлийн жагсаалтад тусгуулсан орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийн сонгон шалгаруулалтыг эрчимжүүлэх чиглэлээр ТХААГ-тай хамтран ажиллах;

3. Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг эрчимжүүлж, 2025 онд багтаан нислэгийг эхлүүлэх;

4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч хяналтыг сайжруулах;
5. 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан I улиралд багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах, ИНЕГ-ын хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
6. Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журам, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөө, Албадлагын дүрэм, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр зэрэг бичиг баримтуудыг батлах хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг яаралтай дуусгах;
7. “Дэлүүн болдог” нисэх буудлын барилгын ажил, “Өлгий” нисэх буудлын өргөтгөл, Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, “Чингис хаан” олон улсын нисэх буудалд “шатахуун хангамжийн байгууламж”, “Транзит зочид буудал” байгуулах ажлыг эхлүүлэх зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх;
8. ИНЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах чиглэлийг баримтлан ажиллах. Үүнд:
- Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам болон ИНЕГ, ИНҮТ-ийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлох.
 - Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.
 - 2024 онд хэрэгжүүлж дуусаагүй болон бодлогын бичиг баримт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт туссан төсөл, арга хэмжээнүүдийг бүрэн хамруулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР